



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.1.4 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоол, 2017 оны 116 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, дэд зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлж ажиллахыг тус зөвлөлийн дарга (Г.Өнөрбаяр)-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/78, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/50 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/НО  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүн**

Дарга	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Дэд дарга	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга
Гишүүд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэд дарга Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэд дарга Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дэд дарга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын захирал Стандарчилал, хэмжил зүйн газрын Стандарчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын газрын дарга Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч

Монголын Сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбооны тэргүүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны гүйцэтгэх захирал

Монголын дауны холбооны гүйцэтгэх захирал

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн дарга

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны зөвлөх эцэг эхийн хөтөлбөрийн зохицуулагч

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн гишүүн


“Түгээмэл хөгжил” төвийн тэргүүн

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Хан-Уул дүүргийн салбар зөвлөлийн тэргүүн

Нарийн  
бичгийн дарга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/110  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн ажиллах журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл (цаашид “дэд зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагаа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдах зэргийг хэрэгжүүлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг салбарын зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

1.2. Дэд зөвлөлийн үйл ажиллагаа Монгол улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ болон энэхүү журмыг удирдлага болгож мөрдөж ажиллана.

1.3. Дэд зөвлөл нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх хүрээний ажил, тэргүүлж буй яамны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх, салбар дундын бодлого, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах болон хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд боловсрол, дэд бүтэц, хүртээмжийн болон бусад асуудлаар холбогдох байгууллагад санал, зөвлөмж, чиглэл хүргүүлж болно.

### **Хоёр. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн зохион байгуулалт**

2.1. Дэд зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ.

2.2. Дэд зөвлөлийн дарга нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, дэд дарга нь тус яамны Хүн амын хөгжлийн нэгж хариуцсан дарга байна.

2.3. Нарийн бичгийн дарга нь тус яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн нэгжийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна. Зөвлөлийн хуралдаанд санал өгөх эрхтэй.

2.4. Дэд зөвлөл нь холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.5. Дэд зөвлөл нь яамны албан бичгийн хэвлэмэл хуудас болон тэмдгийг хэрэглэнэ.

2.6. Дэд зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зардлыг төсөвт жил бүр тусгах замаар санхүүжүүлнэ.

2.7. Дэд зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах ба яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтан, мэргэжилтнүүд чиг үүргийн дагуу

төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг хийж гүйцэтгэнэ. Төлөвлөгөөг тус зөвлөлийн дарга батална.

2.8. Дэд зөвлөлийн тухайн онд хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас болон бүтэн жилээр гаргаж тухайн оны 7 дугаар сар, дараа жилийн 1 дүгээр сарын дотор Ерөнхий сайдын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажлын албанд хүргүүлнэ.

### **Гурав. Дэд зөвлөлийн хуралдаан**

3.1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл нь жилд 3-аас доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын болон гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно.

3.2. Дэд зөвлөлийн гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.3. Дэд зөвлөлийн даргын эзгүйд хуралдааныг дэд дарга даргална.

3.4. Дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал, холбогдох материалыг дэд даргад танилцуулсны үндсэн дээр дарга хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг тогтооно. Хэлэлцүүлэх асуудлаар шийдвэр гаргахаар бол шийдвэрийн төслийг хавсаргасан байна.

3.5. Дэд зөвлөлийн хуралдаан болохоос ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хэлэлцэх асуудлын төлөвлөгөө холбогдох материалыг гишүүдэд хүргүүлнэ. Хуралдааны материалыг Зөвлөлийн гишүүдийн цахим хаягаар хүргүүлж болно.

3.6. Дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааны материалыг хүлээн авсан боловч хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцоогүй гишүүний бичгээр ирүүлсэн саналыг хүчинтэйд тооцох бөгөөд төлөөлөл оролцуулж болно. Зөвлөлийн гишүүнийг төлөөлөн хуралдаанд оролцож буй тохиолдолд уг төлөөлөл нь саналын эрхгүй байна. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.7. Дэд зөвлөлийн гишүүн нь салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлж болно. Гишүүн зөвлөлөөс даалгасан үүргийг биелүүлж түүний явц, үр дүнг хуралдаанд танилцуулна.

3.8. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Дөрөв. Дэд зөвлөлийн эрх, үүрэг**

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбогдох хууль, тогтоомж журам, дүрэм, бодлогын бичиг баримтыг боловсронгуй болгох санал зөвлөмж гаргана. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах, Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийтийн тээвэр, зам, барилга байгууламж, мэдээллийн хүртээмж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг сайжруулах зорилгоор санал, зөвлөмж холбогдох байгууллагуудад тавих;

4.2. Тухайн салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, орчны болон мэдээллийн хүртээмжийн үйл ажиллагааны явц, үр дүнд хийсэн үнэлгээний тайланг хэлэлцэж санал, зөвлөмж гаргах;

4.3. Тухайн салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, орчны болон мэдээллийн хүртээмжийн үйл ажиллагааны явц, үр дүнд хийсэн үнэлгээний тайланг хэлэлцэж санал, зөвлөмж гаргаж болно.

---000---